



Mongolia's Soft Power policy: Selected Issues of History and Tradition

Nanzaddorj Jalbajav

Ph.D, Professor, Research institute advisor, Shihihutug University, Mongolia

E-mail address: jalbajav@shihihutug.edu.mn

Received: 20 January 2026

Revised: 15 March 2026

Accepted: 23 March 2026

Published online: 30 March 2026



ABSTRACT

This article provides a concise analysis of the concept, significance, origins, and historical evolution of soft power policy, as well as its current state, prospects, and prevailing trends. It also examines the role played and contributions made by the Mongolian state in the development and implementation of this policy. The authors analyze the interrelationship between Mongolia's traditional “Golden Bridle Policy” and modern soft power policy, identifying their similarities and differences. The article further argues that the social and spiritual foundations of soft power policy lie in a country's sustainable economic, social, and cultural development, as well as in citizens' patriotism, civic education, and active engagement in public life. The scholarly novelty of the article lies in articulating these conceptual linkages and foundations in a systematic manner.

Keywords: soft power policy, foreign policy, sustainable development, national values and enlightenment, patriotism and civic education.

Монголын төрийн зөөлөн хүчний бодлого: Түүх, уламжлалын зарим асуудал

Нанзаддорж Жалбажав

Шихихутуг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн зөвлөх, доктор (Ph.D), профессор,

jalbajav@shihihutug.edu.mn

ХУРААНГУЙ

Өгүүлэлд “Зөөлөн хүчний бодлого”-ын утга учир, ач холбогдол, үүсэл, төлөвшилийн түүх, өнөөгийн байдал төлөв, хандлага, энэхүү бодлого үйл ажиллагаанд Монголын төр улсын гүйцэтгэсэн үүрэг, оруулсан хувь нэмрийн тухай товч өгүүлсэн болно. Зохиогчид Монгол төрийн “Алтан аргамжийн бодлого”, “Зөөлөн хүчний бодлого”-ын уялдаа холбоо, ижил төсөөтэй болон ялгаа, түүнчлэн зөөлөн хүчний бодлогын нийгмийн болон оюун санааны үндэс нь улс орны эдийн засаг, нийгэм, соёлын тогтвортой хөгжил, иргэдийн эх оронч үзэл, хүмүүжил, амьдралын идэвхтэй байр суурь болохыг тодорхойлсонд өгүүллийн шинэлэг тал нь болно гэж үзэж байна.

Түлхүүр үгс: зөөлөн хүчний бодлого, гадаад бодлого, тогтвортой хөгжил, үндэсний үнэт зүйлс соён гэгээрүүлэх, эх оронч үзэл хүмүүжил.

Оршил

Зөөлөн хүч (soft power) нь гадаад бодлогод өргөн хэрэглэгддэг, бусдад албадлага, хүч хэрэглэх бус харин соёл, үнэт зүйл, бодлого, нэр хүндийн нөлөөгөөр өөрийн зорилгод хүрэх бодлогын нэгэн хэлбэр юм. Судалгаанд зөөлөн хүчний үзэл санааны түүхэн хөгжил, онолын үндэслэл, Монголын нүүдлийн соёл иргэншил, төр ёсны уламжлалтай уялдах байдал, өнөөгийн Монгол Улсын гадаад бодлогын хүрээнд хэрэгжих боломж, ач холбогдлыг шинжлэх ухааны үүднээс авч үзэв.

Судалгааны зорилго нь зөөлөн хүчний бодлогын онолын суурь, түүхэн эх үүсвэрийг тодруулж, түүнийг Монголын төрийн “алтан аргамжийн бодлого”, нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлстэй харьцуулан шинжлэх, орчин үеийн Монгол Улсын гадаад бодлогын хүрээнд хэрэгжүүлэх боломж, чиглэлийг тодорхойлоход оршино.

Судалгааны таамаглал нь: зөөлөн хүчний бодлого нь зөвхөн орчин үеийн их гүрнүүдийн хэрэглээ бус, харин нүүдэлчин монголчуудын төр ёс, аж төрөх арга ухаанд эртнээс бүрэлдэн тогтсон бөгөөд өнөөгийн Монгол Улсын гадаад бодлогын чухал оюуны ба практик суурь мөн гэсэн санаанд тулгуурлав.

Сэдвийн судлагдсан байдлыг авч үзвэл Ж.Най, Ж.Уэтерфорд, Ким Жон Ре, Л.Курас, Д.Ундрах, Д.Уламбаяр нарын дотоод, гадаадын судлаачид зөөлөн хүчний бодлогын онол, практикийг олон талаас нь тайлбарласан боловч Монголын нүүдлийн соёл иргэншил, төр ёсны уламжлалтай системтэй уялдуулсан судалгаа харьцангуй хомс хэвээр байна. Иймд энэхүү судалгаа нь уг орон зайг нөхөх шинэлэг оролдлого болох ач холбогдолтой.

Судалгааны арга зүй: Судалгаанд түүхэн-харьцуулсан, анализ-синтезийн, баримт бичгийн шинжилгээний болон онолын ерөнхийлөн дүгнэх аргазүйг ашиглав. Үүнд Монгол Улсын гадаад бодлогын хөх ном, Үндсэн хууль, олон улсын байгууллагын баримт бичиг, дотоод гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээл, түүхэн эх сурвалжууд (Марко Поло, “Монголын нууц товчоо” зэрэг)-ыг суурь хэрэглэгдэхүүн болгож задлан шинжиллээ.

Судалгаа нь Монголын төр ёс, нүүдлийн соёл иргэншлийн түүхэн үе шатууд (Их Монгол улс, Манжийн эрхшээл, тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, орчин үе)-ыг хамруулан авч үзсэн бөгөөд чанарын судалгааны арга давамгайлсан болно.

Судалгааны үр дүн: Судалгааны үр дүнд зөөлөн хүчний үзэл санаа нь МЭӨ VI–V зууны үеийн Лао Зыгийн сургаалаас эхтэй философийн үндэслэлтэй бөгөөд Жозеф Найгийн онолоор орчин үеийн гадаад бодлогын шинжлэх ухаанч ойлголт болон хөгжсөнийг тогтоов.

Мөн зөөлөн хүчний бодлогын практик эх сурвалж нь нүүдэлчин монголчуудын төр барихуйн арга ухаанд тод илэрч байсныг түүхэн баримтаар нотлов. Их Монгол улсын үед эзлэгдсэн ард түмний “сэтгэлийг хураах”, чөлөөт худалдааг дэмжих, эдийн засгийн харилцааг түгээмэлжүүлэх замаар бусдыг өөртөө татах бодлого хэрэгжиж байжээ.

Орчин үеийн судлаачдын дүгнэлттэй харьцуулахад зөөлөн хүч нь зөвхөн их гүрнүүдийн нөлөөллийн хэрэгсэл бус, жижиг, буурай улсуудын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах чухал бодлого болох нь Норвег, Бутан, Грек, Сингапур, БНСУ зэрэг улсын туршлагаар батлагдаж байна.

Хэлэлцүүлэг: Судалгааны дүнгээс үзэхэд Монголын төрийн “алтан аргамжийн бодлого” болон зөөлөн хүчний бодлого нь зорилго, үнэт зүйлийн хувьд төсөөтэй боловч хэрэглээний хүрээ, арга хэрэгслийн хувьд ялгаатай байна. Алтан аргамжийн бодлого нь дипломат харилцаанд төвлөрсөн бол зөөлөн хүчний бодлого нь соёл иргэншил, байгаль, түүх, хүний эрх, иргэдийн амьдралын чанар зэрэг өргөн хүрээг хамардаг.

Монгол Улсын зөөлөн хүчний бодлогын оюуны суурь нь иргэдийн эх оронч үзэл, соён гэгээрэл, хууль дээдлэх ухамсар, байгальд ээлтэй хандлага юм. Энэ нь Чингис хааны сургаал, нүүдлийн соёлын үнэт зүйлс, буддын шашны энэрэнгүй үзэлтэй гүнзгий уялдаг.

Орчин үеийн олон улсын харилцаанд хүчний зөрчил, байгаль орчны доройтол, геополитикийн хурцадмал байдал нэмэгдэж буй нөхцөлд Монгол Улсын энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт гадаад бодлого, гуравдагч хөршийн бодлого нь зөөлөн хүчний бодлогын чухал илэрхийлэл болж байна.

Үндсэн хэсэг: Зөөлөн хүч (англи. soft power) “Гол төлөв гадаад бодлогод хэрэглэдэг томьёо бөгөөд бодлого хэрэгжүүлэх нэгэн хэлбэр юм. Бусдад хүчээр бус өөрийнх нь сонирхол, сайн дурынх нь үндсэн дээр нь тулгуурлан хүсэл сонирхлоо гүйцэлдүүлж түүнд нөлөөлөхийг” хэлдэг байна.

Түүхэн байдал: Өөрийн эрх мэдлээ тогтоохын тулд “зөөлөн хүч”-ийг ашиглах санаа нь МЭӨ VI-V зуунд амьдарч байсан эртний хятадын гүн ухаантан Лао Зыгаас гаралтай гэж судлаачид үздэг байна. Тэрээр “Дэлхий дээр уснаас илүү зөөлөн биет байхгүй, гэхдээ ус нь хамгийн хатуу биетийг ч устгаж чадна” гэсэн нь үүнийг баталж байдаг. Мөн түүний “Зохицлыг ойлгоно гэдэг мөнх чанарыг мэдсэн гэсэн үг. Мөнх чанарыг ухаарсан нь харин гэгээрэл юм” гэсэн 2 өгүүлбэр сургаалынх нь утга учрыг илэрхийлдэг гэж үздэг байна.

Джозеф Най /Америкийн улс төрч Джозеф Най 88 насалсан /1937-2025/, шинэ либерализм, мөн зөөлөн хүчний бодлогын онолыг үндэслэгчдийн нэгэн. Тэр бээр: “Зөөлөн хүч нь гаднын улс оронтой харилцахдаа бусдын сонирхол татахуйц соёл, урлаг, үнэт зүйл, гадаад бодлого, санхүүгийн боломжоо ашиглан хүссэн үр дүнд хүчээр бус хүрэхийг хэлнэ. Зөөлөн хүч гэдэг нь тодорхой нэг чиглэлээр өөрийн зорилгодоо хүрэхийн тулд бусад оронтой хамтран ажиллаж эерэг, нааштай ойлголтыг бий болгож нөлөөлөх чадвар юм” гэжээ.

Энэ бол урьд өмнийн болон орчин үеийн түүх, туршлага, чиг хандлагад тулгуурласан шинжлэх ухааны гэмээр томьёолол гэж үзэж байна.

Гэхдээ “зөөлөн хүчний бодлого”-ын анхдагчид нь чухамдаа нүүдэлчин удмын монголчууд бөгөөд тэдний оршин аж төрөхүйн арга ухаанаас ундаргатай гэх үндэс байна.

“Зөөлөн нь хатуугаа, зөв нь буруугаа” гэсэн монгол ардын эртнээс уламжлагдсан мэргэн ухаан буй.

“Олон улсыг эзэлсү

Биеийг нь хураатлаа

Сэтгэлийг нь хураагтун

Сэтгэлийг нь хурааваас

Бие нь хаа очих” гэсэн Чингис богдын сургаал ч бий.

Судалгаанаас үзэхэд Их Монгол улсын үед “зөөлөн хүчний бодлого” үндсэн гурван чиглэлээр хөгжиж байжээ. Үүнд:

“Нэгдүгээрт: Эзлэгдсэн орны ард иргэдийн сэтгэл санааг Монголын төр өөд татаж бишрүүлэх,

Энэ тухайд Марко Поло “Аялал”-даа: “Чингис хааны засаглал шулуун шударга, хүн ардаа ээлтэй, энэрэнгүйг үзсэн бусад орны хүн ард ч түүнтэй өөрсдөө ирж нийлэн, нэгдсээр байв. Нэг мэдэхэд түүнийг дагагсад, дэмжин талархагсад газар, дэлхийг хучин бүрхсэн нь үй түм болсныг үзээд тэр бээр дэлхийг байлдан дагуулж, эзэмшин эрхшээхээр зоригложээ” гэж бичиж үлдээжээ.

Хоёрдугаарт: Чөлөөт худалдааг шүтэх үзлийг бий болгох

Гуравдугаарт: Эдийн засгийг түгээмэлжүүлэхэд чиглэж байв” (Ж.Бор 2022).

Дээрх болон бусад үндэслэлээр “зөөлөн хүчний бодлого бол нүүдэлчин монголчуудын хүн төрөлхтний төр ёс, энх амгалан аж төрөхүй, эв түнжинг эрхэмлэх арга ухаанд оруулсан том хувь нэмэр гэх бүрэн үндэстэй байна. “Нүүдлийн соёл иргэншлийн гол тээгчдийн нэгэн нь болсон монголчууд хүн төрөлхтний түүх, дэвшил хөгжилд үлэмж хувь нэмэртэй ард түмэн. Тухайлбал: чөлөөт худалдааны үзэл санааг Өрнө, Дорнодод түгээж Ази, Европыг холбосон алдарт “Торгоны зам”-ыг гаргасан бөгөөд тэр нь Өрнө, Дорнын соёлын солилцоо болон түүний харилцан холбоотой хөгжилд өргөн боломжийг нээсэн явдал юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулган нэгдсэн хуралдаанаар /2001 оны XI сар/ хэлэлцсэн Соёл иргэншлүүдийн хоорондын хэлэлцүүлгийн нийтлэг хөтөлбөрт “Нүүдлийн соёл иргэншлийн баялаг байдал, бүх хэлбэрийн соёл иргэншлийн харилцааг бэхжүүлэхэд түүний гүйцэтгэсэн үүргийг хүлээн зөвшөөрч, Нүүдлийн соёл иргэншил нь Ази, Европ тив дэх нийгмүүдэд харилцан нөлөө үзүүлж, хүний үнэлэмжийг жинхэнээр харилцан солилцож өрнө болон дорнын нөлөөг уусган авсан болохыг хүлээн зөвшөөрч, Нүүдэлчдийн хүчтэй тогтвортой соёл нь худалдаа наймааны өргөн сүлжээг хөгжүүлэх, засаг захиргаа, соёл, шашны болон арилжааны томоохон төвүүдийг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг мөн хүлээн зөвшөөрч” гэж бичсэн байна (Монгол Улсын гадаад бодлогын хөх ном 2019).

Энэ бол нүүдлийн соёл иргэншлийн гол тээгчдийн нэгэн монголчуудын хүн төрөлхтний эе эвийг эрхэмлэн найрсаг, энх амгалан аж төрөх арга ухаанд оруулсан хувь нэмрийг олон улсын хамтын нийгэмлэг хүлээн зөвшөөрч буй нэгэн нотолгоо гэх үндэстэй юм.

Хубилай цэцэн хааны үед л гэхэд Их Юань улс 1500 гаруй өртөө замыг байгуулж, усан болон хуурай зам харилцааны сүлжээг ашиглан 100 гаруй улс оронтой шууд харилцаж байжээ (Монгол Улсын гадаад бодлогын хөх ном 2019) .

Их Монгол улсын төрийн бодлогын тухайд өмнөд Солонгосын зохиогч Ким Жон Ре: “Мянган жилийн түүхэн хүн” номдоо “Колумб шиг Чингис хаан дэлхийн орон зайг ойртуулан өөрчилсөн. Түүний эзэнт улс XIII зууны эцэс хүртэл Номхон далайгаас Зүүн Европ, Сибириэс Персийн булан хүртэл эзэмшлээ тогтоосон юм. Чингис хаан болон түүний залгамжлагчид Европ, Ази тивийг хамарсан асар өргөн уудам нутагт чөлөөт худалдааны бүсийг бий болгож Дорно-Өрнийн соёл иргэншлийн холбоог бэхжүүлжээ” (Ре 1999). Жак Уэтерфорд абугай: “Монголчууд улс төр, эдийн засаг, оюун санааны хүрээнд үнэхээр олон улсын шинжтэй үйл

ажиллагаа явуулж байсан тэд дэлхийг байлдан дагуулаад зогсохгүй чөлөөт худалдаа, олон улсын түгээмэл хууль, бүх хэлээр уншиж, бичих боломжтой нийтлэг бичиг, үсэгт үндэслэн дэлхийн шинэ дэг журам тогтооход чармайж байлаа” гэж бичжээ (*Уэтерфорд 2012*).

Дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээлээс (*Д.Уламбаяр 2021, Л.Курас 2020*) үзэхэд зөөлөн хүчний бодлого нь зөвхөн их гүрнүүд, /дэлхийн хүчний төвүүд-АНУ, БНХАУ, Баруун Европ, НАТО, ОХУ, Шанхайн Хамтын ажиллагааны нийгэмлэг г.м/-ээс улс төр, эдийн засгийн хүч хэрэгслээр нөлөөллийн хүрээгээ тэлэх/ бодлого төдийгүй бусад, ялангуяа, жижиг болон буурай улс орнуудын тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бэхжүүлэхэд чиглэсэн гадаад бодлого, үйл ажиллагааны цогц хэмээн үздэг байна. Түүнчлэн Улс төрийн зөөлөн хүчний бодлого нь дараах гурван тулгууртай байдаг ажээ. Үүнд:

“Соёл иргэншил /бусдыг бишрүүлэн татах/,

- Улс төрийн нэр хүнд/дотооддоо болон хилийн чанадад санасандаа хүрэх/,

- Гадаад бодлого /хууль ёсны/ (*Д.Ундрах 2022*) Судлаачид зөөлөн хүчний бодлогыг амжилттай хэрэгжүүлж орнуудаас Норвег /баялгийн сангийн үйл ажиллагаа-бусад улсуудад үзүүлдэг буцалтгүй тусламж, хандив г.м Сингапур сайн засаглал, тогтвортой байдал, эдийн засгийн өсөлт хөгжил Бутан иргэдийн сэтгэл хангалуун амьдрал, Грек соёл, иргэншлийн түүх, уламжлалын нөлөөлөл, аялал, жуулчлал зэрэг Монголтой жишиж болох жижиг гэмээр улс орнуудыг онцолдог байна. Мөн Япон шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засгийн хүч чадал, бусад улс орнуудад үзүүлдэг тусламж, дэмжлэг /БНСУ/ сайн жишээ нь “Азийн бие бялдар/ зэрэг соёл урлагийн арга хэмжээ/, зэрэг өндөр хөгжилтэй орнуудын туршлага байна.

Төр ёсны 2200 гаруй жилийн баялаг түүхтэй Монгол Улсын тухайд Монголын төрийн гадаад бодлого, дипломат ёсны “Алтан аргамжийн бодлого” (*Л.Хайсандай 2022*) зөөлөн хүчний бодлого зэрэг олонд хүлээн зөвшөөрөгдсөн харилцан шүтэлцээтэй үнэт зүйлсээрээ хүн төрөлхтний оршихуй, төр барихуйн соёл, арга ухаанд оруулсан үнэтэй хувь нэмэртэй ард түмэн. Монголчуудын гадаад бодлогын эдгээр үнэт зүйлс бүрэлдэн тогтсон түүхийг дараах үндсэн түүхэн үеүдэд ангилан авч үзэж болно гэж үзэж байна. Үүнд:

I. Их Монгол улс, Юань гүрэн, Улс төрийн бутралын үе,

II. Манжийн эрхшээлийн үе /1755-1911/,

III. Тусгаар тогтнолоо сэргээн бататган бэхжүүлэхийн төлөө тэмцлийн үе/ Богд хаант Монгол улсын/ 1911-1921/1924/ , БНМАУ-ын/ 1921/1924/-1961/1990/ үе,

IV. Орчин үе/1990 оноос эдүгээ хүртэл/.

Эхэн үед /I/ Монголын төрийн бодлого эзэнт гүрний сүр хүчээр хөрш болон бусад улсуудаар улсаа хүлээн зөвшөөрүүлэх, харилцан ашигтай худалдаа арилжааг хөгжүүлэн чөлөөт худалдааны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх замаар нөлөөллийн хүрээгээ тэлэх, хадгалж хамгаалахад чиглэж эзэнт гүрэн улсдаа бусдыг бишрүүлэн татах аргыг түлхүү ашиглаж байжээ. Их Монгол улсын сүр хүчний зэрэгцээ эзэнт төрийн шударга, ёс зүйтэй, хүмүүнлэг энэрэнгүй бодлого нь бусдыг өөртөө бишрүүлэн татах удвис болж байжээ. Монгол төрийн бодлогын үеэс үед уламжлагдан ирсэн үндэстэн, угсаатны гарал үүсэл, арьс өнгө, шашин шүтлэг, соёлд

үл ялгаварлах тэгш, хүндэтгэлтэй хандлага, худалдаачид, хөрөнгө оруулагчдад ээлтэй татварын бодлого зэрэг нь зөөлөн хүчний бодлогын нь амжилтын нэгэн үндэс нь болсоор иржээ.

Их Монгол улсын засаглахуйн арга ухааны нэг онцлог нь төрийн хэрэгт эрдэм боловсрол, ур чадвар, туршлагыг түших хэрэг байжээ. Эзэнт “төрийн бодлогод өрнө эртний уламжлалтай “тал нутгийн сэхээтнүүдийн мэдлэг чадвар, туршлагад түшиглэж байсныг түүхий баримтууд гэрчилдэг байна” (Ш.Бира 2001).

Энд мөн 1218 онд Чингис хааны Чаньчун бомбод илгээсэн заллагын захидал, бомбын Монголд морилсон түүх , Өгөдэй, Хубилай сэцэн хаадын “Чингис хаан морин дэл дээр байгуулсан улсыг мориноос буулгүй удирдаж болохгүй” гэсэн хаан эцгийн сургаалыг даган мэргэн түшмэл Елюй Чу-Цайн зөвлөмжийг төрийн бодлогод баримталж байсан, “... төр, шашин хоёрыг хослон явуулах, эрдэм чадал, ур чадвартай, шударга түшмэлийг түших, иргэдээ соён гэгээрүүлэх, хуулиар засаглах арга ухаан” (Д.Лүндээжанцан 2022) зэргийг дурдаж болно. Их Монгол улсын төрийн бодлого даян дэлхийд энх амгаланг 150 гаруй жил сахиулсан бодлого байсан юм.

Монголын түүхийн бусад /II. III/ үеүдэд харийн түрэмгийлэл, эрхшээлийг эсэргүүцэн тэмцэх, төр улсынхаа тусгаар тогтнолыг сэргээн мандуулах, олон улсаар хүлээн зөвшөөрүүлэх /де-юре, улмаар де фактод хүрэх/ соёл иргэншлийнхээ онцлог, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх, нийгмийг соёлжуулах замаар бусдыг өөртөө татах бодлого баримталж байсан бол эдүгээ /IV/ Монгол Улсын олон улсын нэр хүнд, байр суурийг бэхжүүлэх, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлаа эдийн засгийн бие даасан, хараат бус байдлыг хангах замаар бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хүн төрөлхтний энх тайван аюулгүй байдал энхийг дэмжих арга хэрэгслээр дэмжлэг үзүүлэх, хоёр их хөрш, бусад/ гуравдагч хөршийн/ улс орнуудтай тэнцвэртэй, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зэргээр тууштай энх тайванч бодлогыг хэрэгжүүлж байна. **Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуульд үүнээс хойш** Монголын ард түмэн улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” эрхэм зорилгыг тунхаглан зарласан юм.

Ардчилсан Үндсэн хуулиар Монгол Улсын гадаад бодлогын үндсэн зорилтуудыг:

1. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд

тодорхойлсон юм.

Судалгаанаас үзэхэд Монголын төрийн “Алтан аргамжийн бодлого” болон “Зөөлөн хүчний бодлого” зорилго чиглэл/Монгол Улсын оршин тогтнохуй, хөгжил дэвшлийн гадаад таатай нөхцөл бүрдүүлэх/, арга хэрэгсэл /энхийг эрхэмлэгч бодлого, үйл ажиллагаа/-ийн хувьд төсөөтэй, ижилсүүлэх хүчин зүйлүүд байгаа боловч лавшруулан үзвэл ялгаа зааг байна гэж үзэж байна. Алтан аргамжийн бодлого нь “цэвэр” гадаад бодлого, дипломат ёсны хүрээнийх бол зөөлөн хүчний бодлого нь улс орныхоо баялаг түүх, соёл иргэншлийн үнэт зүйлс, онгон дагшин үзэсгэлэнт байгаль зэрэгтээ тулгуулан бусад улс орон, гадаадын иргэдийн анхаарал, сонирхлыг өөртөө татах, хамтын ажиллагаа, түншлэлийн найдвартай, таатай орчин бүрдүүлэхэд чиглэгддэг гэх үндэстэй байна. Монгол улсын иргэдийн эрх, эрх чөлөөний баталгаажилт, бие бялдар, оюуны хөгжил ч бусдыг татах хүчин зүйлд зүй ёсоор орох буй заа.

Сүүлийн үед олон судлаачид монголчуудад заяагдсан /газар нутаг, байгалийн баялаг г.м/, хөлс цус, хүч хөдөлмөр, авьяас билгээр нь бүтээгдсэн үндэсний үнэт зүйлсийн тухай их ярьж бичиж байна. Учир нь эдгээр үнэт зүйлс нь монгол хүний эх орон хэмээх өлгий орчны утга учир, ноён нуруу нь, бусад улс үндэстний хүн ардыг өөртөө татах, “бишрүүлэх” хүч нь болдог байна

Үндэсний ийм эрхэм үнэт зүйлсэд:

- Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, тэдгээрийг тээгч эзэн нь болсон Монгол Улсын иргэн, түүний эрх, эрх чөлөөний баталгаажилт,
- Монголчуудад мөнх тэнгэрээс заяагдсан өлгий нутаг, түүний баялаг. Монгол Улсын нутаг дэвсгэр нь хоёр их гүрний хооронд орших бөгөөд Өрнө-Дорныг холбосон замын уулзварт, уул тал, ой хээр, говь цөл нутаг хосолсон, эрдэс баялаг элбэг, байгалийн үзэсгэлэнт тогтолцоо ихтэй, Монголын баялаг түүхийн гэрч болсон түүх дурсгалаар баян, хулан, тахь хавтгай аргаль угалз зэрэг ховор ан амьтантай орон юм.
- Мянга мянган жил бүтээгдэн дархлагдсан “хорвоод хосгүй, дахин давтагдашгүй” монгол соёл иргэншил, түүний үндэс нь болсон нүүдлийн мал аж ахуй, Монгол аж төрөх арга ухаан, монгол ахуй, амьдралын хэв маяг;
- Монголын ард түмний оюуны их соёл, монголчуудын хэл сэтгэлгээ, утга зохиол, яруу найраг, дуу хөгжим, шинжлэх ухаан, сурган боловсруулах, хүмүүжүүлэх, төлөвшүүлэх арга ухаан, эх оронч үзэл, хүмүүжил,
- Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Арван буянт номын цагаан түүх”, “Болор тууль” зэрэг Монголын түүхийн эх сурвалж бичгүүдэд болон дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын судар номд бичигдэн үлдсэн) Монгол улс, үндэстний үнэн бодит түүх;
- Монгол Улсын (Монгол Улсын иргэний) олон улсын нэр хүнд, байр суурь зэргийг багтаан томъёолдог байна (*Б.Даши-Ёндон 2023*).

Зарим судалгаанаас үзэхэд “мөнгө, эрх мэдэл, албан тушаал, шашин шүтлэг” зэргийг Монгол Улсын иргэдийн амьдралын үнэт зүйлсэд багтаасан байдаг ажээ (*Б.Содбилэг 2025*).

Тайлбар. Үнэт зүйлс гэдэг ойлголтыг бид үнэлэгч субъектийн хувьд объектын (үнэлүүлж буй юмс үзэгдэл гэсэн утгаар нь) нийгмийн, нийтэд хүлээн

зөвшөөрөгдсөн ач холбогдол гэсэн утгаар тааруулж хэрэглэж буй билээ. Өөрөөр хэлбэл үнэт зүйлс хэмээх философийн болон соёлын ойлголт нь үнэ цэнтэй биет тодорхой юмсыг бус харин абстракт (хийсвэрлэсэн) сэтгэлгээний үүднээс тухайн юмс, үзэгдэл (жишээ нь түүх, бахархал, эх оронч үзэл хүмүүжил гэх мэт)-ийн үнэт чанар, ач холбогдлыг илэрхийлж буй юм. Энэ бол нийгэмд, тухайн улс үндэстэнд нийтээрээ хүлээн зөвшөөрдөг, оюун санаа, үйлдэл, үйл ажиллагаандаа баримжаа болгодог нийтлэг зүйлүүдийг л үнэт зүйлс хэмээн ойлгоно гэсэн үг юм.

Монгол Улсын зөөлөн хүчний бодлогын чухал үндэс суурь нь иргэдийн маань эх оронч элгэн халуун үзэл, итгэл хүмүүжил билээ. Чухамдаа иргэдийн эх орныхоо өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлаж ойлгосон, хөгжил, дэвшил, аюулгүй байдлынх төлөө зүтгэх идэвхтэй байр сууринд төрийн зөөлөн хүчний бодлого амжилттай хэрэгжинэ. Тиймээс хүн ардынхаа “сэтгэлийг хураах” буюу хүн ардаа соён гэгээрүүлэх төрийн зөөлөн хүчний бодлогын оюун санааны үндэс гэж үзэж байна. Далай лам, Э.Кант нарын мэргэдийн сургаснаар соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үндсэн зорилго нь иргэдээ муу муухай, нүгэл хилэнцийг тэвчих, жигших, буян хураах, байгаль эхээ хайрлан хамгаалах, эх оронч байх, ээ эвээ хичээх зэрэг сайн үзэл санаа, сайн үйлсийг түгээх, бүтээх үйлс болдог байна.

Төрийн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго нь:

1. Эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх, Өдгөө цагт Монгол Улсын иргэний эх оронч үндэсний үзэл, хүмүүжлийг Монголчуудын удмын санд шингэн үеэс үед уламжлагдан ирсэн эх орноо хайрлан хамгаалах, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийнх нь төлөө бие сэтгэлээ харамгүй зориулах нийтлэг мэдрэмж, ухамсар, оюуны дотоод хүч тэнхээ, түүний бодит илрэл болсон амьдралын идэвхтэй байр суурь гэж ойлгох нь зүйтэй гэж үзэж байна. Философич Б.Даш-Ёндон абугай “Монголын төлөө гэсэн сэтгэл Бидний зүрхэнд уяатай” гэсэн их Нацагдоржийн “монголчуудын сэтгэлийг илэрхийлсэн” шүлэглэлийг ишлээд” Бид энэ уяаг сулруулах ёсгүй, харин ч улам чангалах ёстой. Бид-Эх орны үрс боловч эх орон маань бидний хүүхэд билээ. Иймд бид Эх орноо хүүхэд шигээ хайрлах ёстой. Эх орноо “зүрхэндээ уяж чадаагүй тийм хүмүүс эх орноо дээрэмддэг байна, бас харийнханд дээрэмдэх бололцоо олгодог, эсхүл ийм юмыг зүгээр хараад суудаг, эсхүл хамтарч нийлдэг ажээ. Ийм байдал бол зүй бусаар баяжигчдын “зүрх юм” (Б.Даш-Ёндон 2024) гэжээ. Эдгээр үгс эх оронч үзэл санаа хүний шударга ариун явдал, амьдралын идэвхтэй байр сууриных нь үндэс нь болдгийг хэлж дээ гэж ойлгогдож байна.

2. Ертөнцийг үзэхүй, сүсэг бишрэл, байгаль эхээ “амилуулан шүтэж, хайрлан хамгаалах монгол арга ухааныг төлөвшүүлэх, хойч үедээ өвлүүлэх,

Монголчууд бүр эртнээс мөнх хөх тэнгэрийг шүтэж, хаад ноёд, ихэс дээдэс, төрөө тэнгэр язгууртай хэмээн хүндлэн дээдэлж ирсэн ард түмэн. Хожуу дэлгэрсэн бурхны шашин, бусад шашин шүтлэгийн зүйлс нь монголчуудын ертөнцийг үзэхүйн цөм нь болж байсан.

“Байгал орчныг хамгаалах нь хүмүүнлэг энэрэнгүй үйлс ... Монголчууд онгон тансаг газар нутаг, уул усаа тэнгэрийг шүтэх үзэлтэй эвцэлдүүлэн хайрлан хүндэлж, ариглан ашиглаж ирсэн зан заншлын хийгээд хууль цаазын арвин баялаг уламжлал, өвөрмөц соёл, амьдралын дадал туршлагатай ард түмэн.” (О.Амархүү 2009)

3. Хууль дээдлэх ухамсар сэтгэлгээ, дадал заншлыг төлөвшүүлэх, хөгжүүлэх. Баялаг түүх, уламжлалтай монголын төр ёс, хууль цааз нь шударга ёсны ёс суртахуунд суурилсан, энэрэнгүй, нигүүлсэнгүй боловч үл дагагсдад хатуу ширүүн нэхэлтэй, тиймээс ч монголчууд “төр төмөр нүүртэй” гэж ярьдаг. Б.Чимид: “Шударга ёс зүй хийгээд нийгмийн бусад хэм хэмжээ Үндсэн хуульд багтсан байх зэрэг гол шинж бүрдсэн байвал хууль дээдлэх ёс бүрдсэн байгаа нь тэр”.

Бид Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал зэрэгт тодорхойлсон гадаад бодлогын үндсэн зорилтуудын дагуу Монгол Улсын зөөлөн хүчний бодлогын үндсэн чиглэлүүдийг дараах байдлаар томъёолж байна. Үүнд:

- *Эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжил*, бие даасан хараат бус байдал, иргэдийн амьжиргааны сайн чанарыг ханган хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах,
- *Нийгмийн амьдралын бүх хүрээнд хууль дээдлэхүй, шударга ёс, сайн засаглалыг хэвшүүлэн тогтоох, хөгжүүлэх*, үндэсний эв нэгдлийг тууштай хамгаалж бэхжүүлэх,
- *Эх орны онгон дагшин байгаль эхээ хайрлан хамгаалах, байгаль ээлтэй ногоон хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх*,
- *Энхийг эрхэмлэгч, олон тулгуурт гадаад бодлого, гуравдагч хөршийн бодлогоо тууштай хэрэгжүүлж НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцооны чадавх, боломжийг нэмэгдүүлэх*. Энд Монгол Улс зөвхөн өөрийгөө батлан хамгаалах зориулалтай зэвсэгт хүчинтэй байх, бүх нийтийн оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалтын стратеги бүхий батлан хамгаалах бодлого нь төрийн зөөлөн хүчний бодлогын нэгэн үндсэн зүйл болохыг онцолж байна. Монгол Улсын Зэвсэгт хүчин нь олон улсын хамтын нийгэмлэг-НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд болон улс орныхоо энхийн бүтээн байгуулалтад идэвхтэй оролцох хүн амд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хуулиар хүлээсэн үүрэгтэй бөгөөд Монгол Улсын иргэд, залуусын иргэний төлөвшил, эх оронч хүмүүжлийн жинхэнэ сургууль болж байдаг. Хүн ам цөөнтэй, эдийн засаг, санхүүгийн чадавх боломж хязгаарлагдмал Монгол Улс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцоогоороо дэлхийд тэргүүлэх орнуудын зэрэгт байгаа нь төрийн зөөлөн хүчний бодлогын нэг бодитой үзүүлэлт нь юм.
- *Аялал, жуулчлалыг хөгжүүлэх*, Монгол Улсад гадаадын иргэд- хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, суралцагсад, аялан жуулчлагчдад ээлтэй, соёлтой татварын, нийгмийн, аюулгүйн орчин төлөвшүүлэх, эх орноо гадаадад сурталчлах үйл ажиллагааг эрс сайжруулах, энд хүмүүнлэгийн харилцааны бүх нөөц боломж, дипломат болон олон улсын байгууллагууд, гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн хүч бололцоог ашиглах, эрх ашгийг нь хамгаалах ажлыг нэгдсэн бодлого төлөвлөлтэйгөөр хэрэгжүүлэх, үүнд олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлэх.

Зарим судлаачид /Д.Уламбаяр, Г. Төмөрчулуун, Д.Ундрах, Д.Ууганжаргал г.м/ Зөөлөн хүчний бодлогыг улс орнуудын байршил, соёл, иргэншлийн онцлог, хөгжлийн түвшин зэрэгт нийцүүлэн бүсчлэн хөгжүүлэх, улс орнууд дахь монгол судлал, монгол хэл, соёлын зэрэг сургалт судалгааны байгууллагууд, хувь

хүмүүсийг дэмжих, хамтран ажиллах, мөн Монгол Улсын хөгжлийн түвшин, аялал жуулчлалын үйлчилгээний чанар, соёл, гадаадын хөрөнгө оруулалт, татварын бодлогын тогтвортой бус байдал, төрийн үйлчилгээ дэх хүнд суртал, авлига зэрэг сөрөг хүчин зүйлүүдийг саармагжуулах санал зөвлөмжүүд нь анхаарал татсан, санаа авууштайг онцлон тэмдэглэж байна.

Эдүгээ өнөөгийн ертөнцөд нэг талаас улс үндэстнүүдийн, хүмүүнлэгийн харилцаа өргөжин, соёлжиж байгаа хэдий ч нөгөө талдаа хүчээр түрүү барих бодлого нөлөөтэй хэвээр байна. Дэлхийн олон бүс нутагт хүчний төвүүд, улс үндэстнүүдийн зөрчил тэмцэл ширүүсэж зэр зэвсэг хангинан хүн төрөлхтөнд дайны аюул нүүрлэн байна. Байгаль нийгмийн харилцаанд ч хүмүүнлэгийн энх амгалан оршихуйд ч нөлөөлөхүйц, аюул эрсдэл ихсэж хүнээс байгаль орчиндоо хандлагаа эрс өөрчлөхийг шаардах боллоо. Хүний үйл ажиллагаа, үйлдвэрлэл, шинжлэх ухаан технологийн дэвшил, цаг агаарын дулаарал зэргээс үүдэлтэйгээр дэлхийн мөсөн бүрхүүл хайлж, агаар мандлын амьдралыг хамгаалагч озоны давхарга цоорч гэмтэн газрын хөрс цөлжин нуур цөөрөм, газрын хөрс цөлжин, гол мөрөн олноор ширгэж дундарч, ой мод шингэрч ан амьтан цөөрч байна.

Ийм цаг үед Монголын төр улсын хэрэгжүүлж буй олон тулгуурт энх тайванч бодлого, гуравдагч хөршийн бодлогын зэрэгцээ хүн ардаа соён гэгээрүүлэх, үндэсний эе эвээ хичээх, байгаль эхдээ хайр гамтай байх, түм түмэн мод тарих, эрүүл саруул аж төрөх зэрэг сайн үйлс нь зөөлөн хүчний бодлогоороо улс түмний энх амгаланд оруулж буй бодитой хувь нэмэр нь болой.

Талархал

Энэхүү судалгаанд ашигласан дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээл, Монгол Улсын гадаад бодлогын хөх ном, Үндсэн хууль болон түүхэн эх сурвалжуудын зохиогчдод талархал илэрхийлье.

Дүгнэлт

“Зөөлөн хүчний бодлого” нь Монгол төрийн “алтан аргамжийн бодлого”, хуулиар, номын ёсоор засаглахуйн /“сайн засаглал”/-н нэгэн адил монголын төр ёсны эрхэм үнэт зүйл, хүмүүнлэгийн төрт ёсны арга ухаанд оруулсан хувь нэмэр нь юм. Энэхүү бодлогын утга учир нь улс орныхоо эдийн засаг нийгмийн тогтвортой хөгжил, сайн засаглал, соёл иргэншлийн дахин давтагдашгүй өвөрмөц байдал, баялаг түүх, байгалийн эрдэс баялаг, хосгүй гоо үзэсгэлэн, хүн ардынхаа найрсаг зочломтгой, нөхөрлөлдөө үнэнч зан чанараар болон Монгол Улсын энхийг эрхэмлэгч олон тулгуурт бодлогын хүчээр хоёр их хөрш, “гуравдагч хөрш”, бусад улс орон, хүн ардын сэтгэл сонирхлыг өөртөө татан найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэн улс үндэстнийхээ тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх бодлого юм.

Эдүгээ “Зөөлөн хүчний бодлого” нь шинжлэх ухааны үндэслэлтэй, глобал /түгээмэл/ үзэгдэл болон хөгжиж байна. Энэ бодлого үйл ажиллагаа нь нэг талаас их гүрэн, хүчний төвүүдээс “Нөлөөллийн хүрээ”-гээ тэлэх, хадгалах, нөгөө талаас жижиг, бага буурай улс орнууд тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бэхжүүлэх /энх амгалан оршихуй, хөгжлийн гадаад таатай орчин бүрдүүлэх/ д чиглэсэн эдийн засаг, соёлын болон дипломат бодлого, арга хэрэгслийн цогц гэж үзэж байна. Зөөлөн хүчний бодлогыг амжилттай хэрэгжүүлж байгаа Монголтой аль нэгэн үзүүлэлтээр

жишиж болох Норвег, Бутан, Грек, БНСУ, Сингапур зэрэг олон улс байна. Тэдний сайн туршлагыг судалж хэрэглэх нь зөөлөн хүчний бодлогыг амжилтад хүргэх нэг арга зам гэж үзэж байна.

Монгол Улсын зөөлөн хүчний бодлогын оюуны гол хүчин зүйл, нэг үндэс нь иргэдийн маань эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө, сайн сайхан аж төрлийн төлөө зүтгэх элгэн халуун эх оронч үзэл хүмүүжил, амьдралын идэвхтэй байр суурь болно. Тиймээс зөөлөн хүчний бодлогоо амжилттай хэрэгжүүлэх нэг гол арга зам бол хүн ардаа эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэхэд чиглэсэн төрийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа гэх бүрэн үндэстэй байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Б.Даш-Ёндон, Ж. Болдбаатар, Ч.Сосорбарам нар. 2023. *Үндэсний ой санамж, үнэт зүйл*. УБ.
2. Б.Содбилэг, Н.Төмөрчөдөр. 2025. ““Үндэсний эв нэгдлийн судалгаа, үр дүн”.” *Стратегийн судалгаа* (97): 7.
3. Д.Лүндээжанцан. 2022. *Монгол хаадын захидал: Монголын төрт ёс, эрх зүйн түүхэн уламжлал*. УБ.
4. Д.Уламбаяр. УБ. *Зөөлөн хүчний бодлогын онол, түүхэн дурдатгал: Олон улсын харилцаан дахь зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс*. 2021 .
5. Д.Ундрах, Д.Ууганжаргал. 2022. “Монгол Улсын зөөлөн хүчний бодлогыг дэлхийн бүс нутгын онцлогт тохируулан хэрэглэх нь /зарим улсын жишээтэй харьцуулсан нь/.” *researchgate* .
6. Б.Даш-Ёндон, 2024. “Хүн ба шим ертөнц.” *Философи, эрх зүйн судлал* (39): 247.
7. Ж.Бор. 2022. *Монгол улсыг хүрээлэн буй геополитик, геостратегийн гадаад орчин: Өнгөлөн далдлалт, төөрөгдүүлэлт, бодит байдал, хашлага давах боломж*. УБ.
8. Л.Курас, Б.Базаров. 2020 . *Орос-Монголын харилцаан дахь зөөлөн хүчний арга хэрэгслийг нэгтгэх нь* .
9. Л.Хайсандай. 2022. *Монгол төрийн алтан аргамжийн бодлого*. УБ.
10. 2019. *Монгол Улсын гадаад бодлогын хөх ном*. УБ.
11. О.Амархүү. 2009. *Монголын орчин цагийн экологийн эрх зүй*. УБ.
12. Ре, Ким Жон. 1999. *Мянган жилийн түүхэн хүн*. УБ.
13. Уэтерфорд, Жак. 2012. *Чингис хаан өнөөгийн ертөнцийг үндэслэгч*. УБ.
14. Ш.Бира. 2001 . «Монголын төрт ёсны үүсэл хөгжил .» In *Монгол түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа 3 боть* , 210. УБ.